

## МОНГОЛЧУУДЫН ТӨВД ХЭЛНЭЭС ОРЧУУЛСАН ЗОХИОЛЫН ТОЙМ

Д.Бүрнээ<sup>16</sup>

**Товч утга:** Монголчууд бүр 13-14 зууны үеэс төвд хэлнээс ном судар орчуулж байсан түүхтэй. Эдгээр ном судар буддын шашны агуулгатай байснаас гадна тэжээх ухаан, одон зурхай, зохист аялгуу, учир шалтгааны ухаан зэрэг буддын утга зохиолын олон салбарыг хамарч байв. Монгол орчуулгын үйлсэд төв халх, буриад, ойрад, өвөрлөгч аймгийн үе үеийн эрдэмтэн мэргэд, гүүш хэлмэрч нар оролцож орчуулгын асар их өвийг монгол бичгээс гадна тод, дөрвөлжин, соёмбо зэрэг бичгээр бичиж туурвисан нь өдгөө Монгол улсад төдийгүй дэлхийн бусад орны номын санд ч хадгалагдаж байна. Монголын хаад нийгэм, улс төрийн зорилгоор төвдийн улааны болон шарын шашныг дэлгэрүүлж, Төвд, Монгол хоёр орны хооронд утга зохиолын харилцаа холбоо тогтсон тэр цаг үеэс төвд хэлнээс ном судар орчуулж эхэлжээ. Ялангуяа шарын шашин хүчтэй дэлгэрсэн 17-18 зуунд төвд хэл эрдэм боловсролын хэлний үүргийг гүйцэтгэх болж, монгол лам нар төвд хэлээр бүтээлээ туурвиж, төвд хэлнээс ном судар орчуулах үйл ч өрнөн хөгжсөн байна. Чухам энэ үед Монголын орчуулгын түүхэнд томоохон байрыг эзлэх төвд Ганжуур, Данжуурыг монголын нутаг бүрээс цугларсан хэлмэрч гүүш нар орчуулж дуусгах, ариутган шүүх ажлыг амжилттай хийж гүйцэтгэсэн төдийгүй төвд хэлнээс ном судар орчуулах гарын авлага болох "Мэргэд гарахын орон" нэрт толь бичгийг зохион найруулжээ. Тус толь бичигт орчин цагийн орчуулгын онолын холбоотой олон асуудлыг дэвшүүлэн тавьснаас гадна их, бага таван ухааны нэр томъёоны орчуулгыг журамлан тогтоосон нь монгол орчуулгын түүхэнд чухал үйл явдал болсон юм. Төвд хэлнээс ном судар орчуулсан түүхээс үзвэл орчуулгын эхэн үед буддын шашны нэр томъёог санскрит хэлээр сэргээн буулгах уйгарын орчуулгын аргыг баримталж, төвд үг хэллэгийг зээлж авах биш, харин орчуулах хандлагатай байсан бол шарын шашны нийгмийн үүрэг, нэр нөлөө хүчтэй болж ирсэн 17-19 зуунд төвдүүдийн санскрит, хятад хэлнээс ном судар орчуулахдаа аливаа нэр томъёог хуулбарлан буулгаж байсан тэрхүү аргыг даган мөрдсөн төдийгүй Ганжуур, Данжуурын олон үеийн монгол орчуулгыг бээжин барын төвд эхийг үндэс болгож засан найруулсан түүхтэй. Буддын шашин номын агуулгатай төвд ном судрыг зонхилон үгчилж орчуулж байсан бол уран зохиол, ялангуяа иргэний чиглэлийн ном судрыг утга төгөлдөр уран яруу орчуулахаас гадна аман бичгийн орчуулгын баялаг уламжлал байсныг ч дурдах нь зүйтэй.

20 дугаар зууны 38 оны хэлмэгдүүлэлтийн жилээс мөнхүү зууны дунд үе хүртэл шашин номын орчуулга үндсэндээ зогссон байсан бол дэлхий дахинд

<sup>16</sup> МУИС, ШУС, ХУС, МХХШТ-ийн профессор, доктор

гарсан улс төр, нийгмийн нааштай өөрчлөлт Монголын нийгэм соёлын амьдралд нөлөөлсний үр дүнд төвд-монгол орчуулгын ажил ч сэргэсэн юм. Гандан хийдийн дэргэд шашин номын соён гэгээрүүлэх үйл эрхэлсэн Номын гэр хэмээх сайн дурын байгууллага үйл ажлаа явуулж, Монгол Улсын Их сургуульд төвд хэлийг заан сургаж, ШУА-ийн ХЗХ-ийн дэргэд Төвд судлалын тасаг байгуулагдан, хуучин нэрээр Ардын Эмнэлгийн хүрээлэн, Түүх, Философийн хүрээлэнгээс төвд хэлээр уламжилж ирсэн монголын анагаах ухаан, түүх, гүн ухааны ном зохиолыг судлах болсон нь төвд ном орчуулах ажил сэргэх хүчин зүйл болсон юм. 1990 оноос өмнө иргэний чиглэлийн уран зохиолын орчуулга зонхилон гарч байсан бол 1990 оноос хойш эрдэм ухааны төрөл бүрийн салбарыг хамарсан орчуулга гарчээ. Монголд гарсан ардчилсан хөдөлгөөн, дэлхий дахинд гарсан нийгмийн өөрчлөлтийн нөлөөгөөр монголчууд уламжлалт шашнаа чөлөөтэй шүтэх, өв соёл, ёс заншлаа судлах таатай нөхцөл бүрдсэн билээ. Түүнчлэн орчуулгын баялаг өвийн дийлэнх хувь монгол бичгээр уламжилж ирсэн учир эдгээр орчуулгыг шинэ кирил бичигт хөрвүүлэх, уламжлалт орчуулгын эхийг хуулбарлан буулгаж хэвлүүлэх ажлыг ч хийж байна.

**Түлхүүр үг:** судрын орчуулга, Ганжуур, Данжуурын орчуулга; утгачилсан ба аман бичгийн орчуулга, хөрвүүлэг

Монголчууд 13-14 дүгээр зуунаас төвд хэлнээс ном судар орчуулж ирсэн түүхтэй. Тэр цаг үеийн орчуулгаас устаж үрэгдсэн нь цөөнгүй бөгөөд зарим номын тасархай хуудас олдсоны дийлэнх нь шашин номын холбоотой ч иргэний чиглэлийн зохиол орчуулж байсны гэрч бол төвдийн эрдэмтэн Сажа бандид Гунгаажалцангийн /1182-1251/ зохиож, тарнич тойн Сономгарагийн орчуулсан “Субашид” болно. Энэ үеийн орчуулгыг хожуу үеийн орчуулагчид үндэс болгосон тухай Ганжуур, Данжуурын төгсгөлийн үгд цөөнгүй тэмдэглэсэн зэргээс үзвэл 13-14 дүгээр зуунд орчуулгын үйл дэлгэрч байсан байна. Бидэнд мэдэгдэж буй тухайн үеийн орчуулагчид бол Чойжи-Одсэр, Шаравсэнгэ, Сономгара нар юм. Чойжи-Одсэр, Сономгара нарын орчуулга судрын үгчилсэн орчуулгын шинжтэй, харин Шаравсэнгийн орчуулга “үгчилсэн орчуулгаас эрс ялгаатай” уран сайхны орчуулга болохыг судлаачид тэмдэглэжээ<sup>17</sup>. “Банзрагч”<sup>18</sup>, “Бодичарияаватара”-г Чойжи-Одсэр орчуулсан бол Шаравсэнгэ бээр “Алтангэрэл”, “Бурханы арван хоёр зохионгуй”-гаас гадна “Банзрагч”-ийг орчуулсан тухай тус зохиолын төгсгөлийн үгд тэмдэглэжээ.

Төвд хэлнээс ном судар орчуулж байсан эхэн үед харь үгийг аль болох орчуулах, төвд үгийг хуулбарлан авах бус, харин санскритаар сэргээн орчуулж байсан онцлогтой. Энэ нь тухайн үед буддын шашны ном зохиолыг орчуулахад уйгарын орчуулгын нөлөө хүчтэй хэвээрээ байсныг илтгэн харуулна. Тухайн

<sup>17</sup> Ц.Дамдинсүрэн, Два колофона монгольской книги “Золотой блеск”, - Монголын уран зохиолын уламжлалын асуудал, УБ., 1984, 164.

<sup>18</sup> “Банзрагч”-ийг Чойжи-Одсэр орчуулсан эсэх талаар судлаачид санал зөрж байна. Харин төвд, монгол сурвалж бичгийн мэдээнд орчуулсан гэж тэмдэглэсэн буй.

үед буддын шашин, буддын утга зохиолын нэр томъёоны орчуулга нэг мөр болж хэвшин тогтоогүй, санскрит үг хэллэг зонхилж байсан билээ<sup>19</sup>.

16-18 дугаар зууны үед төвд хэлнээс ном судар орчуулах үйл далайцтай өрнөсөн байна. Энэ үед Хөх хотын Ширээт гүүш, харчины Аюуш гүүш, халхын Алтангэрэл увш, ойрадын Зая бандид Намхайжамц нарын зэрэг нэртэй орчуулагчид бүтээлээ туурвиж байв. Орчуулгын сэдвийн тухайд авч үзвэл шашин гүн ухааны ном судраас гадна түүх, уран зохиол буюу иргэний чиглэлийн ном судрыг орчуулж байжээ. Энэ үеийн орчуулгын томоохон төлөөлөгчийн нэг болох Ширээт гүүш цорж өмнөх үеийн уран яруу орчуулгын өвийг уламжлан авч, монгол хаад ноёд, хатдын дуртгаснаар олон сайхан орчуулгаа туурвижээ<sup>20</sup>. Харчины Аюуш гүүш бол нэртэй орчуулагч<sup>21</sup> байснаас гадна али-гали хэмээх санскрит, төвд үгийг галиглах монгол үсгийн тогтолцоог боловсруулж, харь гаралтай үгийг хөрвүүлэн асуудлыг шийдсэн юм. Монголчуудын дунд дэлгэрч нийт ард түмний шүтээн төдийгүй хүртээмж болсон олон хөлгөн судрыг халхын Алтангэрэл увш<sup>22</sup> орчуулсан нь сонгодог бичгийн өмнөх үеийн монгол хэлний дурсгалыг судлах чухал хэрэглэгдэхүүн болохоос гадна төв халхын орчуулгын дэгийг судлахад ч ач холбогдолтой. Энэ үеийн орчуулгын томоохон төлөөлөгчийн нэг болох ойрадын Зая бандид Намхайжамц шавь нарын хамт 200 гаруй ном судрыг орчуулсан нь тод бичгээр уламжилж ирснийг онцлон дурдах ёстой<sup>23</sup>. Зая бандид Намхайжамцын орчуулга нь төвд нэр томъёог санскритаар сэргээх уламжлалт орчуулгын аргыг баримтлаагүй, харин төвдүүдийн санскрит нэр томъёог зээлж авах бус, орчуулдаг уламжлалыг даган мөрджээ. Өөрөөр хэлбэл, төвд орчуулгын дэгийг чанд баримталсан гэж хэлж болно. Энэ нь Зая бандид Намхайжамцын шашин номын үзэлтэй холбоотойгоос гадна “үгчилсэн орчуулгын зарчмыг тогтоосон” тухайд онцлог юм<sup>24</sup>.

Энэ үеийн орчуулгын нэг томоохон ололт бол 13-14 дүгээр зуунаас эхэлсэн төвд Ганжуур, Данжуурын орчуулгыг эцэслэн дуусгаж, хянан тохиолдуулж барласан явдал юм. Энэтхэгийн санскрит болон пали хэлээр уламжилж ирсэн буддын утга зохиолын дурсгалыг төвдүүд эмхтгэж Ганжуур, Данжуур хэмээн нэрлэсэн билээ. Ганжуур гэдэг бол зарлигийн орчуулга хэмээсэн утгатай төвд үг бөгөөд Бурхан багшийн зарлиг сургаалын эмхтгэл юм. Түүнд энэтхэгийн аман зохиолын үлгэр домог, адилтгал зүйрлийг ашиглан

<sup>19</sup> Д.Бүрнээ, “Үлгэрийн далай”-н монгол орчуулгуудыг хэлшинжлэлийн үүднээс харьцуулах нь,- Д.Бүрнээ, Д.Энхтөр, Уламжлалт орчуулгын судлалд, УБ., 2003, 9.

<sup>20</sup> Д.Бүрнээ, “Үлгэрийн далай”-н монгол орчуулгуудыг хэлшинжлэлийн үүднээс харьцуулах нь,- Д.Бүрнээ, Д.Энхтөр, Уламжлалт орчуулгын судлалд, УБ., 2003, 35-51.

<sup>21</sup> Д.Бүрнээ, Ганжуурыг орчуулахад Аюуш гүүшийн оруулсан хувь нэмэр, Acta Mongolica, Centre for Mongol Studies, National University of Mongolia, Ulaanbaatar, 2007, Vol.7 (291), pp.149-155.

<sup>22</sup> Ц.Дамдинсүрэн, ХҮИ зууны үеийн орчуулагч Алтангэрэл увшийн тухай зарим мэдээ, - Монголын уран зохиолын уламжлалын асуудал, УБ., 1984, 117-125.

<sup>23</sup> Х.Лувсанбалдан, Тод үсгийн дурсгалууд, УБ., 1975, 125-128.

<sup>24</sup> Л.Хүрэлбаатар, Орчуулгын товчоон /сонгодог орчуулгын зарчим, уран чадварын асуудалд/, УБ., 1995, 61.

тайлбарласан буддын шашин гүн ухааны агуулгатай олон түүх цадиг багтан орсон учир буддын утга зохиолын дээж бичиг гэж үзэж болно. Төвд Ганжуурыг Лигдэн хааны зарлигаар монгол хэлнээ орчуулахад хэдэн хэлмэрч гүүш оролцсон тухай Дарма гүүшийн бичсэн "Алтан хүрдэн мянган хигээст" хэмээх сударт тэмдэглэжээ. Түүнийг иш татвал "...Гунгаа-Одсэр хэлмэрч эхлэн гучин гурван гүүш нараар Ганжуурыг монгол хэлэнд орчуулан алтаар бичвэй" гэсэн байна<sup>25</sup>. Түүнээс гадна Ганжуурын төгсгөлийн үгд 50 гаруй хэлмэрч гүүш оролцсон тухай тэмдэглэжээ<sup>26</sup>. Ганжуурыг Алтан хааны үед буюу 1602-1607 оны хооронд анх бүрэн орчуулж дуусаад, 1628-1629 онд ариутган шүүж, 1717-1720 онд хэвлэхэд урьд орчуулсан олон хүний нэрийг дурдаагүй орхижээ. Тийнхүү нэр дурдаагүй орчуулагчдийг олж мэдэхэд монгол бичмэл Ганжуур бидэнд тус болж байна. Тухайлбал, манай нийслэл хотын Үндэстний номын санд хадгалагдаж буй бүрэн бус бичмэл Ганжуурын 25 зохиолын төгсгөлийн үгээс бид хэлмэрчийн нэрийг мэдэж авч байгаа билээ<sup>27</sup>. Нөгөөтэйгүүр, Ганжуурын зарим орчуулагчийн нэргүй зохиолыг тухайн зохиолын нийтэд дэлгэрсэн гар бичмэл эхээс тодруулсан туршлагыг ч бид анхаарч үзэх нь чухал юм<sup>28</sup>.

Ганжуурыг орчуулахад Аюуш Ананд, Ширээт гүүш, Гунгаа-Одсэр, Дархан лам Самдансэнгэ, Шаравсэнгэ нарын зэрэг олон гүүш оролцжээ. Ганжуурыг орчуулахаас гадна хэвийг бүтээх, ариутган шүүх, хуулан бичихэд 129 хүн оролцсон байна<sup>29</sup>.

1000 гаруй ном судрыг багтаасан төвд Ганжуурын орчуулгыг хэвлэхийн өмнө ариутган шүүсэн нь нарийн учиртай ажээ. Ганжуурын орчуулга бүр 13-14 дүгээр зуунаас эхэлсэн түүхтэй. Тиймээс хуучны олон зохиолыг багтаасан, нөгөөтэйгүүр олон үеийн орчуулагчийн барьж орчуулсан төвд эх судар нэгэнт устаж олдохгүй болсон, газар газрын орчуулагчийн хэл найруулга өөр өөр байсан зэрэг нь Ганжуурыг ариутган шүүхэд ихээхэн бэрхшээл учруулсан ажээ. Тиймээс хянан тохиолдуулахын тулд юуны өмнө тодорхой арга зарчмыг тогтоож түүнийгээ даган мөрдөх шаардлага тулгарсан байна. Хамгийн гол асуудал бол ямар төвд эхийг барьж засах тухай асуудал байсан болов уу. Ямар ч

<sup>25</sup> Дарма гүүш, Алтан хүрдэн мянган хигээст, монгол бичгээс хөрвүүлж оршил тайлбар, хавсралт хийсэн Т.Жамъянсүрэн, Л.Халиун, УБ., 2006, 86.

<sup>26</sup> Ш.Чоймаа, Ганжуур, Данжуур хийгээд монгол орчуулга, түүнийг судлахын ач тус,- Билгийн гэгээ, Ганжуур, Данжуурын судалгаа, эрдэм шинжилгээний анхдугаар бага хурал, 2013, 22; Ч. Хишигтогтох, Монголын эртний утга зохиолын шинэ судлал, Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо, 1998, 381 /монгол бичгээр/.

<sup>27</sup> Д.Бүрнээ, Үндэсний номын сангийн монгол бичмэл Ганжуурын төгсгөлийн үгээс орчуулагчийг тодруулах нь, Олон улсын монголч эрдэмтэдийн X их хурлын илтгэлүүд, II боть, Монгол хэл соёлын тулгамдсан асуудлууд, УБ., 2012, 45-47.

<sup>28</sup> Монголчуудын дунд "Үлгэрийн далай" хэмээн алдаршсан зохиолыг Хөх хотын Ширээт гүүш орчуулсан болохыг ОХУ-д хадгалагдаж буй гар бичмэл судрын төгсгөлийн үгээс Б.Я.Владимирцов тодруулсан билээ.

<sup>29</sup> Ч.Хишигтогтох, Монголын эртний утга зохиолын шинэ судлал, Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо, 1998; Catalogue du Kanjur Mongol Impime, par Louis Ligeti, Budapest, 1942-44, 342.

байсан Бээжин барын төвд Ганжуурыг баримталж зассан байх бөгөөд ийнхүү засахдаа хуучин орчуулгыг хэл найруулгын талаас нэлээд өөрчлөн засахад хүрсэн нь тухайн орчуулгын төгсгөлд орчуулагчийн нэрийг хүртэл бичилгүй орхиход хүргэсэн байж болзошгүй<sup>30</sup>. Ганжуурын зарим зохиолын монгол орчуулгыг тус зохиолын хамгийн анхны орчуулга гэж үзэхэд түвэгтэй тул тухайн орчуулгын бичмэл, дармал хуулбар, хувилбар зэрэг олон эхийг харьцуулан үзэж, анхны эх мөн эсэх, биш бол анхны эхээс хэр зэрэг өөр болсон буюу хөгжил хувьслын түүхийг ажиглах боломжтой. Төвд хэлнээс ном судар орчуулахад зориулж орчуулгын толь болох даяг буюу дохионы бичиг, ариун бичиг буюу даг-ег хэмээх зүйл хуваасан толь бичиг, дүймин хэмээх түүвэр нэрийн толь буюу хатуу үгийн толь, дадол буюу бэрх үгийн толь тэргүүтэн толь бичиг<sup>31</sup> гарсан ч нэр томъёоны тусгай толь бичиг, гарын авлага байгаагүй учир Ганжуурын орчуулгууд үг хэллэгийн хувьд ялгаа зөрөөтэй болсон ч ямар нэг хэмжээгээр төвд хэлнээс монгол хэлнээ орчуулах арга барил, дадлага туршлага хэрхэн хуримтлагдаж байсныг судлах чухал хэрэглэгдэхүүн болж чадах юм<sup>32</sup>.

Данжуур гэдэг бол шастирын орчуулга хэмээсэн утгатай төвд үг бөгөөд дуун ухаан, тэжээхүй ухаан, урлахуй ухаан, учир шалтгааны ухаан, дотоод ухаан зэрэг их таван ухаан, одон зурхай, зохист аялгуу, илт өгүүлэхүй, эвсүүлэн найруулах, дуурайн бүжиг зэрэг бага таван ухааны 3000 гаруй ном зохиолыг багтаасан буддын утга зохиолын их цоморлиг юм. Түүнийг орчуулахад олон эрдэм ухааны нэр томъёоны орчуулгыг журамлан тогтоох шаардлага тулгарсан учир энэ зорилгод нийцүүлэн "Мэргэд гарахын орон" нэрт толь бичгийг зохиосон байна. Тус толь бичгийн оршилд төвд хэлнээс монгол хэлнээ ном судар орчуулах арга зарчим тухайлбал үгсийн сан, хэлзүйн орчуулгын онолын асуудал, орчуулгын хувиргалын тухай товч өгүүлэхээс гадна орчуулагчийн ёс зүйтэй холбоотой асуудал, уран сайхны орчуулгын тухай, шүлгэлсэн ба үргэлжилсэн үгийн орчуулгын онцлог, орчуулгын зорилго, үнэн зөв орчуулахын ач тус, буруу зөрүү орчуулахын гэм хор, орчуулагч хүний наад захын баримтлах ёс журмын талаар өгүүлэхээс гадна учир шалтгааны ухаан, билиг барамид, мадхьямика, авидарма, винай, тарнийн аймгийн нэр томъёо болон дуун ухаан, урлахуй ухаан, тэжээх ухааны нэр томъёоны орчуулгыг журамлан тогтоосон байна<sup>33</sup>.

<sup>30</sup> Л.Хүрэлбаатар, Судар шастирын билиг, УБ., 2002, 73; Д.Бүрнээ, Монгол Ганжуурыг ариутган зассан тухай асуудалд, Монгол судлал, ЭШБ, боть XXXVII (392), УБ, 2013, 153-157.

<sup>31</sup> Ц.Шагдарсүрэн, Монгол хэлний толь зүйн уламжлал,- Толь бичгийн судлал, Орчин цагийн монгол хэлний үгсийн сангийн судлалын үндэс, УБ., 1986, 194-196; A review of the Tibetan-Mongolian lexicographical tradition, The Mongolia-Tibet interface, PIATS 2003: Tibetan Studies, Proceedings of the Tenth Seminar of the International Association for Tibetan Studies, Oxford, 2003, Managing editor: Charles Ramble. pp.371-379.

<sup>32</sup> Д.Бүрнээ, Ширээт гүүш юмын судрыг орчуулсан тухай, Лам нарын сэтгүүл, 12 сар, №3, 2010, 115-118.

<sup>33</sup> "Мэргэд гарахын орон" толь бичиг дэх орчуулгын онолын холбоотой хэсгийг бүрэн эхээр нь монгол бичгээс кирил бичигт хөрвүүлэн хэвлүүлсэн билээ. Үз.: Д.Бүрнээ, Д.Энхтөр "Уламжлалт орчуулгын асуудалд", УБ., 2003, 300-303.

Данжуурыг орчуулж эхэлсэн нь 13-14 дүгээр зуун бөгөөд 1742-1749 оны хооронд нэгэнт бэлэн байсан хуучин орчуулга дээр шинэ тутам орчуулсан орчуулгыг нэмж, засан найруулж хэвлүүлсэн байна. Данжуурыг орчуулахад Авгын Дай гүүш Агваандампил, гүүш Лувсанлүгдэн, Халхын гүүш Гэлэгжалцан, гүүш Рашижамц, Рагу хутагтын хувилгаан Лувсанчүлтэм нарын зэрэг 200 гаруй алдарт гүүш оролцжээ. Данжуурын орчуулга нь монголын сонгодог бичгийн хэлний орчуулга, түүний дотор утга зохиолын хэм хэмжээ, нэр томъёо зэргийг тогтооход чухал үүрэг гүйцэтгэсэн байна<sup>34</sup>. 108 боть Ганжуур, 225 боть Данжуурын 5000 гаруй зохиолыг багтаасан буддын утга зохиолын цоморлигийг орчуулсан нь монгол орчуулгын түүх, соёлын амьдралд гарсан томоохон үйл явдал болсон юм.

Ганжуур, Данжуурын орчуулга бол санскрит хятад хэлээр уламжилж ирсэн буддын утга зохиолын төвд орчуулга бөгөөд монголчууд тэрхүү төвд орчуулгаас дам монгол хэлнээ орчуулсан хэрэг юм. Тэгвэл монголчууд төвд утга зохиолыг бас шимтэн уншиж, “Гэсэрийн тууж”, “Үлгэрийн ном”, “Милын намтар”, “Милын буман дуулал”, “Бадмагатан”, “Гатан дэн-а”, “Цагаан лянхуан баглаа”, түүний тайлбар, “Субашид” болон түүний тайлбар, “Шидэт хүүрийн үлгэр” зэрэг төвд ардын аман зохиол, уран зохиолыг эх хэлнээ орчуулжээ<sup>35</sup>. “Мааньгамбум”-ыг Зая бандид Намхайжамц, Авгын Цүлтэмлодой нар, “Субашид”-ийн тайлбарыг Цахар гэвш Лувсанчүлтэм, Номтын Ринчен, “Молон тойны эхийн ач хариулсан судар”-ыг Ширээт гүүш, Сөнөдийн Дамбадаржаа гүүш, Халхын Алтангэрэл увш, Зая бандидын шавь Цүлтэмжамц нар орчуулжээ. Түүнээс гадна монголчуудын дунд нэрд гарсан зохиолыг олонтаа орчуулж байжээ. Тухайлбал, Сажа бандид Гунгаажалцангийн зохиосон “Субашид” хэмээх иргэний яруу найргийн зохиол, монголчуудын шашин номын шүтээн болсон “Жадамба” буюу “Найман мянгат” хэмээх зохиолын арав орчим орчуулгыг дурдаж болно. Нэг зохиолын ийнхүү олон орчуулга гарсан нь монголын нүүдлийн аж амьдралтай холбоотой, өөрөөр хэлбэл хэн, хаана ямар ном орчуулж буй талаар мэдэх боломж муутай байснаас үүдэлтэй, мөн тухайн орчуулгыг цаг үеийнхээ хэл найруулгад ойртуулан дахин шинээр орчуулах эрэлт хэрэгцээ байсантай ч холбоотой болов уу. Ямар ч атугай нэг зохиолын олон орчуулга гарсан нь орчуулгын хэл найруулгын хөгжил хувьсал, монгол орчуулгын түүхийг судлахад бас чухал баримт болох юм.

Төвд хэлнээс ном судар орчуулах үйлсэд төв халх, өвөрлөгчид, ойрад, буриад зон олон бүгд оролцож, өөр өөрсдийн орчуулгын арга дэгийг буй болгосон байна<sup>36</sup>. Өмнө дурдсан Зая бандид Намхайжамц болон түүний шавь нарын төвд эхийн хэлзүйг буулгах үгчлэн орчуулах дэгээс гадна буриадын Агын

<sup>34</sup> Ш.Чоймаа, Ганжуур, Данжуур хийгээд монгол орчуулга, түүнийг судлахын ач тус,- Билгийн гэгээ, Ганжуур, Данжуурын судалгаа, эрдэм шинжилгээний анхдугаар бага хурал, 2013, 25.

<sup>35</sup> Ц.Дамдинсүрэн, Монголын уран зохиолын тойм II, УБ., 1976, 500-504.

<sup>36</sup> Л.Хүрэлбаатар, Монгол орчуулгын товчоон /сонгодог орчуулгын зарчим, уран чадварын асуудал/, УБ., 1995, 121.

аймгийн Дэлгэрийн Галсанжамба, Хорын аймгийн Номтын Ринчен хэмээн алдаршсан Лувсанринчен, Агваанлэгшид, Онон Цүүгэл дацангийн ширээт Төгөлдөрийн Галсанжамба нарын зэрэг буриадын эрдэмтэн гүүш нарын орчуулга “толгой тэгшлэн орчуулах зарчим”-ыг баримталсан бие даасан дэг сургууль байсныг Л.Хүрэлбаатар дурджээ<sup>37</sup>.

Төвд-монгол орчуулгын түүх, ялангуяа иргэний номын орчуулгын түүхэнд гарсан нэг онцгой үйл явдал бол Цахар гэвшийн /1740-1810/ орчуулга юм. Түүний бүтээл өмнөх үеийн Шаравсэнгэ /13-14 зуун/, Агваандампил /1700-1780/ нарын орчуулгын уламжлалыг үргэлжлүүлэхийн зэрэгцээ харийн соёлыг монгол хөрсөнд буулган идээшүүлсэн, жинхэнэ уран сайхан орчуулгын хувьд онцлон тэмдэглүүштэй. Түүний “Субашид”-ийн орчуулгыг өмнөх үеийн болон хожуу үеийн орчуулгуудтай харьцуулбал төвд эхийн хэлбэрт огт баригдаагүй, төвд шүлгийн хэлбэрийг монгол шүлэгчийн чөлөөт сэтгэмжээр ургуулан бодож буулгасан утга төгс уран яруу орчуулга болсон билээ. Тиймээс ч тус орчуулгыг эрдэмтэн Ц.Дамдинсүрэн<sup>38</sup> төвд эхийн санааг нэмэн дэлгэрүүлж баяжуулсан, бас шашны утга санааг иргэншүүлсэн, Л.Хүрэлбаатар төвд эхийн санааг авч дуурайлган зохиосон шинжтэй болохыг онцлон тэмдэглэсэн хэрэг юм.

Төвд-монгол орчуулгын түүхэнд аман орчуулгын уламжлал байсныг бас онцлон дурдах ёстой. Энэ нь аливаа төвд номын орчуулгыг цээжээрээ дуудаж хэлдэг, аман бичгийн сонгодог орчуулга юм. Энэ төрлийн орчуулга сургаалын зохиолоос гадна эрдэм ухааны бусад салбар тухайлбал, уран зохиол, тэжээх ухаан, одон зурхай, яруу найргийн онолын хүрээнд ч гарч байсан байна. Аман орчуулга бол судрын орчуулгаас ялгаатай, нийт ард олонд хүртгээмжтэй, ойлгомжтой, бас уран яруу орчуулга байсан бөгөөд түүнийг багшаас шавьд амаар уламжлан өвлүүлж байжээ. Төвд хэлнээс орчуулсан номын дийлэнх нь шашин номын агуулгатай, төвд эхийн хэлбэрийг буулгасан үгчилсэн орчуулга байсан бөгөөд тэрхүү орчуулгыг судрын орчуулга ч гэж нэрлэж заншсан билээ.

19 дүгээр зууны сүүл 20 дугаар зууны эхэн үеийн төвд монгол орчуулгын түүхэнд С.Шагж /1886-1938/, Ц.Дорж нарын орчуулгыг онцлон дурдах хэрэгтэй. Ардын хувьсгалын дараа байгуулагдсан Судар бичгийн хүрээлэнгийн төвд үсгийн орчуулагч, хожим нь Шинжлэх ухааны хүрээлэнгийн жинхэнэ гишүүн, “Монгол үгийн тайлбар толь” болон “Эрэхүй хялбар болгон зохиосон үгийн тайлбар чандманийн эрих”, “Монгол бичиг сурах дөт зам” хэмээх сурах бичиг зохиосон С.Шагж төвд хэлнээс хэд хэдэн ном орчуулжээ. Тэр бээр Их Хүрээний хамба Агваанхайдавын “Хонь, ямаа, үхэр гурвын яриа”, Зая бандид Лувсанпэрэнлэйн зохиосон “Өндөр гэгээний намтар”-аас гадна Туган Лувсанчойжинямын /1737-1802/ “Шэлжи мэлон” хэмээх буддын шашин гүн ухааны онолын чанартай алдартай зохиолыг орчуулсан юм. Энэхүү зохиолыг

---

<sup>37</sup> Мөн тэнд, 129.

<sup>38</sup> Ц.Дамдинсүрэн, О некоторых особенностях деятельности Чахар-гэвши,- Монголын уран зохиолын уламжлалын асуудал, УБ., 1984, 142-147.

гадаадын олон эрдэмтэн судалж өндрөөр үнэлж, тус зохиолоос англи, орос, герман зэрэг хэлнээ хэсэглэн орчуулсан<sup>39</sup> бол эрдэмтэн С.Шагж тус зохиолыг эх хэлнээ бүрэн орчуулсан нь манай Үндэстний номын санд хадгалагдаж байна<sup>40</sup>. Тус орчуулгад төвд үг олон орсон байдаг нь тухайн цаг үеийн онцлогтой холбоотой. Энэ үе бол манай оронд шарын шашны сүм хийдийн нийгмийн үүрэг, нэр нөлөө их байсан, хүрээ хийдийн газар лам нар нэг дор төвлөрөн сууж, хэл яриандаа төвд үг олноор оруулж ярьж байсан нь бичгийн хэлэнд нэвтрэн орсон байна. Тиймээс ч “Алтангэрэл”, “Сундуй”, “Банзрагч”-ийг уншихад тааралддаггүй төвд үг шинэ үеийн зохиолчид болох Д.Нацагдорж, Д.Намдаг нарын зохиолд тааралдаж байна гэж эрдэмтэн Ц.Дамдинсүрэн бичжээ<sup>41</sup>. Түүнээс гадна манай Үндэстний номын санд С.Шагжийн бас нэг өөр зохиолын орчуулга хадгалагдаж байна. Энэ нь “Номын богд цогт их Гамбобагийн тууж чандмань эрдэнэ бүхнээ түгээмэл яруу банжид нирваан эрдэнийн дээд чимэг” хэмээх зохиол юм. Гамбоба /1079- 1153/ бол төвдийн алдарт яруу найрагч Мила богдын /1040-1123/ шавь байжээ. Тус орчуулгын төгсгөлд “... хэмээсэн үүнийг Монгол улсын Олноо өргөгдсөний дөрөвдүгээр он хөх хулгана жилийн цагаан сарын шинийн сайн өдөр нийслэл Их Хүрээний газраа өтөл хуврагийн дүрст Шагж хэмээх бээр төвдөөс монгол үсэгт орчуулан бичиж төгсгөв”<sup>42</sup> гэсэн бол “Болорын толь” орчуулгынхаа төгсгөлд “...хэмээх үүнийг Монгол Ардын намын судар бичгийн хүрээлэнгийн төвд орчуулагчийн хүнд нэрийг хүлээсэн хуврагийн дүрст Шагж хэмээх бээр арван тавдугаар машид гарсны модон хулгана жилийн мэргэшир сарын арван тавнаа төгсгөн орчуулав” гэжээ. Түүнээс гадна төвдийн алдарт даяанч эмэгтэй Мажиг Лавдонмаагийн /1055-1143/ намтрыг бас орчуулжээ.

МУИС-ийн төвд хэлний багшаар ажиллаж байсан Ц.Доржийн орчуулгаас бидэнд мэдэгдэж буй нь Зава Дамдины түүхийн сэдвээр бичсэн “Сэржи дэвтэр” буюу "Алтан дэвтэр" хэмээх томоохон хэмжээний түүхэн шастир болон түүний хураангуй болох “Өлзийт лавай мөшөөсөн дуун” хэмээх судрын орчуулга болно<sup>43</sup>.

1937-1938 оны хэлмэгдүүлэлтийн үеэр эрдэмтэн лам нарыг олноор хороож, монголын оюуны соёлд ихээхэн гарз хохирол болж төвд-монгол орчуулгын түүхэнд ч зогсонги үе болсон билээ. Харин 1950 он гарсаар дэлхий дахинд

<sup>39</sup> Туган Лувсанчойжиням, Болорын толь, орчуулсан С.Шагж, монгол бичгээс кирил бичигт хөрвүүлэн, оршил тайлбар, үгийн хэлхээс хийсэн Д.Бүрнээ, Д.Энхтөр, УБ., 2006, 9.

<sup>40</sup> Лувсанчойжиням, Болорын толь, төвд хэлнээс орчуулсан С.Шагж, монгол бичгээс хөрвүүлэн, оршил, тайлбар бичсэн Д.Бүрнээ, Д.Энхтөр, УБ., 2006.

<sup>41</sup> Ц.Дамдинсүрэн, Монгол хэлэнд орсон төвд үгс,- Монгол хэлэнд орсон санскрит, төвд үг, УБ., 2007, 112.

<sup>42</sup> Номын богд цогт их Гамбобагийн тууж чандмань эрдэнэ бүхнээ түгээмэл яруу банжид нирваан эрдэнийн дээд чимэг, Үндэстний номын сангийн гар бичмэл номын хөмрөг, гар бичмэл судар, 102а тал

<sup>43</sup> Зава Дамдин, Умар зүгийн монгол оронд дээд ном эрдэнэ гарах ёсны домог өлзийт лавай мөшөөсөн дуун эгшиг хэмээх оршвой, төвд монгол хадмал, гар бичмэл,- Лавайн эгшиг, 1998 оны №2, 3-68.

хүйтэн дайны үе намжсан нь монголын улс төр болон оюуны соёлд нааштай уур амьсгалыг авчирчээ. Гандан хийдийн дэргэд Номын гэр, ШУА-ийн дэргэд төвд судлалын тасаг байгуулагдаж, Ардын эмнэлгийн хүрээлэн, ШУА-ийн Түүх, Философийн хүрээлэн зэрэг эрдэм шинжилгээний байгууллагад монголчуудын төвд хэлээр бичсэн ном судрыг судлах, орчуулах ажил ч сэргэсэн билээ. Гандан хийдийн Номын гэрийг эрхэлж байсан хамба С.Гомбожав “Бадарчин Гомбодорж”, “Хөгшин үнээний үг”<sup>44</sup> зэрэг сургаалын зохиолоос гадна монголын эрдэмтэн баарин Дармадалагийн төвд хэлээр бичсэн түүхэн сурвалж бичгийг монгол хэлнээ орчуулжээ. Монгол аман орчуулгын урын санд С.Гомбожав тэргүүтэй лам нар ихээхэн хувь нэмэр оруулсныг шавь нар нь талархан дурсдаг. Дээр дурдсан Номын гэрээс төвд хэлнээс ном судар орчуулах ажлыг эрхлэн гаргаж байсны нэг жишээ бол “Зориуд өгүүлэхүй цоморлиг ба номын бадаг хоёрыг хавсарч судалсан шастир” бөгөөд тус номыг орчуулах үйлд гавж Т.Данзан-Одсэр, гэвш Ш.Ламаажав, С.Иштавхай, Дашдамба нар оролцож С.Гомбожав хянан тохиолдуулж, 1966 онд хэвлүүлсэн байна. Түүнчлэн Эрдэнэпил хамбын орчуулсан Калидасын “Үүлэн зардас”-ын орчуулга, Өндөр гэгээн Занабазарын төвд хэлээр бичсэн “Жинлав цогзолма” буюу “Адистидийн дээдийг хайрлагч эх”-ийн Х.Гаадан хамбын орчуулга гарсан билээ<sup>45</sup>. Далай лам Цанъянжамын “Янагийн дуулал”-ын Ц.Дамдинсүрэнгийн орчуулга, Л.Хүрэлбаатар<sup>46</sup>, Д.Ёндон<sup>47</sup> нарын монголчуудын төвд хэлээр бичсэн сургаалын зохиол, уран шүлгийн орчуулга төвд уран зохиолын орчуулгад томоохон байрыг эзлэх юм. Төвдөч Ч.Алтангэрэл төвд хэлнээс уран зохиол, зохист аялгууны онолоор бичсэн яруу найргийг орчуулах талаар ихээхэн хүч хөдөлмөрөө зориулсан уран бүтээлч юм. Тэр бээр Цахар гэвш Лувсанчүлтэм, Агваанхайдав, Ишданзанванжил нарын төвд хэлээр бичсэн уран зохиолоос түүвэрлэн орчуулахаас гадна Ноён хутагт Данзанравжаагийн бүтээлээс 40 орчим яруу шүлгийг монголчлон буулгажээ<sup>48</sup>.

1990 оны ардчилсан хөдөлгөөний нөлөөгөөр Монгол оронд үндэсний соёл, ёс зан заншлаа судлах ажил сэргэхийн сацуу төвд хэлнээс ном судар орчуулах, уламжлалт орчуулгыг шинэ кирил бичигт хөрвүүлэн буулгах ажил ч өрнөн дэлгэрэв. 1990 оноос өмнө буюу социализмийн үед тухайн үеийн үзэл суртлын нөлөөгөөр зонхилон уран зохиолын чиглэлийн ном судрыг орчуулж байсан бол шинэ үед төвд хэлнээс уран зохиол төдийгүй буддын гүн ухаан, тэжээх ухаан,

<sup>44</sup> Алтан хүрдэн, Монгол зохиолчдын төвд хэлээр туурвисан бүтээлийн дээжсийн цоморлиг, хэвлэлд бэлтгэсэн Л.Хүрэлбаатар, УБ., 1992, 69-71.

<sup>45</sup> Тус зохиолыг Ш.Бира, Ш.Чоймаа нар монгол хэлнээ бас орчуулжээ.

<sup>46</sup> Цахар гэвш Лувсанчүлтэмийн “Цэнгээн наадмыг тэвчих дуун”, Найман Жамбалдоржийн “Уулын ном” тэргүүтэн шүлэг найргийн орчуулгын түүвэр гарав,- Алтан хүрдэн, УБ., 13-17, 22-23, 34-47, 48-68, 90-103 дугаар тал. Мөн Жамьянгаравын зарим шүлэг найргийн орчуулгыг Жамьянгарав судлалын тэргүүн ботид Д.Ганболд эмхтгэн 2013 онд хэвлүүлжээ.

<sup>47</sup> Ноён хутагт Данзанравжаа, Агваанхайдав нарын шүлгийн Д.Ёндонгийн түүвэр орчуулга,- Алтан хүрдэн, УБ., 17-22, 76-90.

<sup>48</sup> Ч.Алтангэрэл, Монгол зохиолчдын төвдөөр бичсэн бүтээл, I дэвтэр, УБ., 1967, II дугаар дэвтэр /Д.Равжаа/, УБ., 1968.

урлахуй ухаан, одон зурхай зэрэг олон салбар ухааны ном судрыг орчуулах ажил сэргэсэн билээ. Тухайлбал түүхийн чиглэлээр төвдийн түүхч Даранатын “Жагар чойнжун” буюу “Энэтхэгийн түүх”-ийг Л.Тэрбиш /2000 он/, Цэмбэл гүүшийн “Хорчойнжун” буюу “Монголд шашин ном дэлгэрсэн” тухай өгүүлсэн түүхэн сурвалжийг Л.Тэрбиш, Р.Бямбаа нар /1997 он/, Гүн Гомбожавын “Жанаг чойнжун” буюу “Хятадын түүх”-ийг Д.Цэдэв /1996 он/, Сүмбэ хамба Ишбалжирын “Цо онбы лоржүй” буюу “Хөх нуурын түүх”-ийг Д.Дашбадрах /1997 он/, Зава Дамдины “Алтан дэвтэр”-ийг С.Гантөмөр /2014 он/, төвдийн түүхч Браггон шавдүн Гончогдамбаравжайгийн “Чойнжун намтаржи товъёог” буюу “Түүхийн номын товъёог”, тавдугаар Далай лам Лувсанжамцын “Жалва ави дэвтэр” буюу “Тавдугаар ялгуусны дэвтэр” хэмээх сурвалж бичгийн монголын түүхэнд хамаатай хэсгийг Д.Бүрнээ, Д.Энхтөр /2003 он/, “Бодь мөрийн явдал ёсны шимийг хураангуйлсан гарын авлага” /2004 он/, “Очроор огтлогч нэрт хөлгөн судар”-ыг Г.Мягмарсүрэн /2009 он/, Өндөр гэгээн Занабазарын төвд намтрыг Ш.Бира, Ш.Сонинбаяр нар /1995 он/, Дамцигдоржийн намтрыг Ш.Сонинбаяр /2011 он/, Зонхавын намтрыг Д.Наранцэцэг /2012/, Зава Дамдины намтрыг Ш.Сонинбаяр, Сүмба хамба Ишбалжирын намтрыг Л.Тэрбиш /2011 он/, бандид хамба Жамьянгаравын намтрыг Ч.Ганболд /2013/ нар тус тус орчуулжээ. Түүнээс гадна буддын гүн ухааны чиглэлээр Шантидэвагийн “Бодьсатвын явдалд орохуй” /1998 он/, Лувсанбалдан гавжийн “Бодьсатвын явдалд орохуй шастирын дугуйт тайлбар” /2009 он/, Зонховын “Их бодь мөрийн зэрэг” /2004 он/, энэтхэгийн гүн ухаантан мэргэдийн зохиосон “Хутагт хос судрын номын зүйл”-ийн /2009 он/ Т.Булганы орчуулга гарсан билээ. “Бага бодь мөрийн зэрэг”-ийг бурханч лам Г.Пүрэвбат /2002 он/, “Бодь мөрийн зэргийн хөтөлбөр амар мөр”-ийг С.Гантөмөр /2014 он/, Зонхавын “Бодь мөрийн зэрэг”-ийг П.Бадрал /2006 он/<sup>49</sup>, Батаа равжамбын “Рашааны үсэрвэр” хэмээх “Бодь мөрийн зэрэг”-ийн тайлбарыг Ж.Ерөөлт, Павонхагийн “Тэтлэхүйн гарын авлага”-ыг Ц.Сансарбат /2011/, Зонхавын “Сайн номлолын зүрхэн”-ийг С.Мөнхтайван /2010 он/, Зава Дамдины гүн ухааны зохиолоос түүвэрлэн С.Янжинсүрэн, Р.Алтансүх, Б.Ариунзул нар /2012/ тус тус орчуулжээ. Уран зохиолын чиглэлээр энэтхэгийн алдарт сургаалын зохиол “Дармапада”-гийн төвд хэлээр уламжилж ирсэн эхийг Л.Тэрбиш /2008 он/, Гүнтэн гэгээний зохиосон “Гал, ус, салхи, модны шастир”-ыг И.Дэмбэрэл /2012/, Зая бандид Лувсанпэрэнлэйн бичсэн “Утгын гучин таван чимгийн үлгэр өгүүлэхүй эсэрваагийн хөвгүүнийг баясгах дуун эгшиг” зохиолоос Д.Бүрнээ /2012 он/, “Субашид” болон түүний тайлбарыг Д.Мөнх-Эрдэнэ /2001/, Бичээч цорж Агваандоржийн “Эрхэм их хэрэгт үгийн тэмдэглэл”-ийг Б.Няммягмар, Дагпу Лувсандамбижалцангийн “Саран хөхөөний тууж”-ийг С.Гантөмөр /2006 он/, “Энэтхэг орны тэмдэглэл”-ийг Г.Мягмарсүрэн /2010 он/ нар орчуулсан байна. Зурхайн ухааны чиглэлээр “Үрийн зурхай болор толь” тэргүүтэй гурван

<sup>49</sup> П.Бадрал, Непко хэвлэлийн газраас эрхлэн гаргаж буй Агнистын гэгээ цувралаар буддын шашин, гүн ухаан, уран зохиол болон зан үйлийн холбоотой 15 номыг төвд болон бусад хэлнээс монгол хэлнээ орчуулжээ.

боть номыг Л.Тэрбиш /2000 он/, Цахар гэвш Лувсанчүлтэмийн “Увидасын утгын хураангуй” хэмээх бүтээлийг Д.Даваасүрэн /2010 он/ орчуулжээ. Түүнчлэн шашны зан үйлийн чиглэлээр Ч.Хатанбаатар “Дара эх бурханд өргөн дөрвөн хот мандал тахил”-ыг /2002 он/, “Улаан сахиусны гар дэвтэр”-ийг Б.Батсанаа /2005 он/, “Бурхан багшийн лагшнаа сүншүг өргөсөн ёсны тэмдэглэл тунгалаг тодорхой толь”-ийг Г.Мягмарсүрэн /2010 он/, Дара эхийн гарал үүсэлтэй холбоотой ном судар болон Дара эхийн холбоотой магтаал, уншлагыг Ч.Гүнзээ /2015 он/, бандид Цэвэлванчигдоржийн “Хишиг дуудах” судрыг Я.Ганзаяа /2015 он/, Дэсрид Санжаажамцын “Газрыг шинжих ёсны тухай” судрыг Б.Няммягмар /2015 он/ нар тус тус орчуулжээ.

Уламжлалт анагаах ухааны чиглэлээр ном судар орчуулах үйлд Ч.Баавгай, И.Дэмбэрэл, түүх, гүн ухааны зохиолын орчуулгад С.Лодой нарын ахмад үеийнхэн хувь нэмрээ оруулсныг энд онцлон тэмдэглэх ёстой. Тухайлбал, монголын алдарт маарамба Лүнриг Дандарын “Монголын уламжлалт анагаах ухааны түүх” /1993/, “Анагаах ухааны дөрвөн үндсийн тайлбар оршвой”, /1996 он/, “Лхантавын бэрх үгийн тайлбар алтан өнгөт арүрийн эрихэс” /1993 он/ тэргүүтэн судрыг И.Дэмбэрэл орчуулжээ. Лүнриг Дандарын “Халуун хүйтэн өвчнийг магадлан шинжлэх нь” судрыг Б. Болдсайхан /1993 он/, Сүмбэ хамба Ишбалжирын /1704-1788/ “Рашааны цагаан шүүдэр”-ийг Ш.Болд, Дагва нар /1999 он/, Тарган бандид Цэвэлванчигдоржийн “Малын өвчний судар”-г Д.Цэдэв /1992 он/ товчлон орчуулжээ.

Монголчуудын төвд хэлээр бичсэн номын бүртгэлийг С.Гомбожав анх хийсэн бөгөөд түүнийг Р.Бямбаа үргэлжлүүлж “Монголчуудын төвд хэлт бүтээлийг судлах монгол билиг” нэрт цувралаар 2004-2013 оны хооронд нийт 9 ботийг гаргаж, зохиогчдийн сүмбүмийн гарчигийг орчуулж, зарим зохиогчдийн намтрын холбоотой мэдээ баримтыг оруулжээ. Монголчуудын төвд хэлээр бичсэн бүтээлийг сурталчлах, судлах талаар Гандан хийдийн дэргэдэх “Лавайн эгшиг” хэмээх бурхан шашны судлал, мэдээллийн сэтгүүл чухал үүрэг гүйцэтгэсэн билээ. 1996 оноос өдгөө хүртэл гарсаар байгаа тус сэтгүүлийн дугааруудад буддын шашин, утга зохиолын холбоотой ном зохиолын орчуулгаас хэвлэн нийтэлж ирснийг тэмдэглэх нь зүйтэй болов уу. Түүнчлэн ШУА-ийн ХЗХ-ийн Төвд судлалын тасгаас 2011 оноос эрхлэн гаргаж буй Төвд судлалын 15 цувралаар монгол, төвд мэргэдийн эрдэм ухааны төрөл бүрийн салбараар бичсэн бүтээлийн хуучин орчуулгыг шинэ кирил бичигт хөрвүүлэх, хуучин орчуулгыг эхээр нь хэвлэх, шинэ тутам төвд хэлнээс эх хэлнээ орчуулан хэвлэн нийтэлж, олон түмний хүртээл болгох талаар чармайн ажиллаж буйг онцлон тэмдэглэх нь зүйтэй.

Монголчуудын төвд хэлнээс орчуулсан судар номын дийлэнх нь худам монгол бичгээр уламжилж ирсэн учир өдгөө зарим номыг төвд хэлнээс шинэ тутам орчуулахаас гадна монгол бичгээр бүхий хуучин орчуулгыг шинэ кирил бичигт хөрвүүлэх ажил 1990 он гарсаар идэвхжсэн билээ. Үүнд анагаах ухаан,

одон зурхай, зохист аялгуу, урлахуй ухаан гээд буддын утга зохиолын салбар ухаан тус бүрийн холбоотой орчуулгын хөрвүүлэг гарч байна. Тухайлбал, “Цогт цагийн хүрдэн” соёлын төвөөс монгол дармал Ганжуур, Данжуурыг монгол бичгээс кирил бичигт хөрвүүлэн нийтлэх ажлыг 2011 оноос эхэлснийг дурдууштай. Энэ нь манай улсад 1990 оноос хойш буддын шашны сүм хийдийг дахин сэргээн байгуулж, сүм хийдийн дэргэдэх дацан сургууль, зарим Их, дээд сургуульд төвд хэл бичгийг заан сургах болсон, эрдэм шинжилгээний байгууллага, хүрээлэнгүүд уламжлалт шашин соёлын судалгаанд анхаарлаа хандуулах болсон зэрэг нийгмийн эрэлт хэрэгцээтэй холбоотой гэж үзэж байна.

Ийнхүү төвд хэлнээс эрт дээр үеэс өдгөө хүртэл үргэлжилж буй монгол орчуулгыг тоймлон үзвэл манай үе үеийн хэлмэрч орчуулагчид монгол орчуулгын урын санг баяжуулахад ихээхэн хувь нэмэр үзүүлжээ<sup>50</sup>. Нэн ялангуяа монгол бичиг, тод бичгээр уламжилж ирсэн арвин их орчуулгын дурсгал бол бидний монголчуудын оюуны соёлын асар том өв болох билээ. Эдгээр орчуулгын зарим нь манай улсад байхгүй зөвхөн гадаадын ном санд хадгалагдаж буй учир бид тэдгээр орчуулгыг цаашид хуулбарлан авах, судлах ажлыг бас орхигдуулахгүй хийх ёстой байна. Түүнээс гадна уламжлалт орчуулгын хэл найруулгаас өнөө үеийн хэлмэрчид бас давхар суралцах ёстой болов уу. Ялангуяа “Мэргэд гарахын орон” толь бичгээр тогтоосон нэр томъёог орчуулгадаа мөрдөж байгууштай. Учир нь төвд хэлтэй гэгдэх хүн бүр дур зоргоороо нэр томъёог буулгаснаас болж, нэг нэр томъёоны олон орчуулга гарч, уншигчдыг төөрөлдүүлж байна. Монгол бичгээс хөрвүүлэх ажлыг ор нэрийн төдий хийсэн байдал ч мэр сэр ажиглагдах тул хэлний мэргэжлийн хүмүүст үзүүлж, засаж залруулахыг анхааруулж байна. Шашин номоо бодсон ч тэр, хувь хүний ажлын хариуцлагыг бодсон ч тэр төвд хэлнээс ном судар орчуулах ажилд чин сэтгэлээс хандан, эх монгол хэлээ сайтар судалж, уламжлалт орчуулгын сонгодог зохиолоос сайтар суралцаж, үгд бус, утгад шүтэн орчуулахыг залуу орчуулагч нартаа уриалъя.

### Резюме

Монголы имеют богатую переводческую традицию. Начиная с 13-14 века по сегодняшний день монголы перевели с тибетского языка большое количество сочинений. Переводы этого периода отличаются от последующих переводов тем, что слова и термины не переводятся с тибетского, а ставится их санскритское заимствование. В истории монгольского перевода 17-18 век был знаменателен тем, что в этот период был завершён перевод тибетского Канджура, и Танджура. В переводе Канджура, в котором содержатся наставления Будды Шакьямуни, буддийские легенды и джатаки, приняли участие как свидетельствуют исторические сочинения тридцать три

<sup>50</sup> Энэхүү өгүүлэлд орчуулагчдийн зарим төлөөлөгчийг оруулсан бөгөөд бүх орчуулагчийг дурдах боломж байсангүй. Өвөр монголчууд сүүлийн үед төвд хэлнээс ном судар их орчуулж буй тухай тусгайлан өгүүлэх хэрэгтэй гэж үзсэн учир энд мөн оруулсангүй.

переводчика. В переводе Танджура, который содержит богатую буддийскую литературу, охватывающей литературу по логике, философии, филологии, искусству и медицине приняли участие более чем 200 переводчиков. При переводе Танджура был составлен тибетско-монгольский словарь специальных терминов буддийской литературы "Мэргэд гарахын орон" /Источник мудрецов/, который явился важным руководством для переводчиков приехавших из разных регионов тогдашней Монголии. Учёные считают, что именно при переводе Канджура, Танджура и оформился классический монгольский письменный язык.

Перевод буддийских сочинений этого периода является по большей части дословным, который является свидетельством верности тибетскому оригиналу. Перевод же сочинений имеющих светский характер отличается художественностью и образностью языка.

В истории монгольского перевода тридцатые годы 20 века отмечаются периодом застоя, вследствие политической репрессии охватившей Монголию. В 50-е годы, особенно начиная с 90-х годов начинается возрождение тибетско-монгольского перевода. Если в 50-90-е годы были переведена по большей части тибетская литература имеющая светский характер, то в 90-е годы преобладает перевод религиозной литературы.